“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 09 сарын 01 өдөр Дугаар А/13 Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Налайхын үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн төсөвт суулгахыг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-т даалгасугай.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан менежер (Д.Ганзориг)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.РАДНААБАЗАР

ATA14401 9025010318 5890683

“Налайхын үйлдвэрлэл, технологийн парк”
ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2026 оны
09 дугаар сарын 21 -ны өдрийн 4/13
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмууд нь энэхүү хөтөлбөрийг, боловсруулан баталж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1.Албан хаагчийн ажиллах урам зориг, хүсэл зорилгыг бий болгох, сэтгэл ханамжийн баталгаатай байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн, хөдөлмөрийн харилцаан дахь урамшуулал, идэвхжүүлэлтийн аргад тулгуурласан олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1.Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

3.1.1.Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх

3.1.2.Албан хаагчдыг орон сууцаар хангах, амьдрах нөхцөлийг сайжруулах боломжийг судлах

3.1.3.Ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх

3.1.4.Албан хаагчдын сурч, хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх

3.1.5.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх

3.1.6.Албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дээрх сэтгэл ханамжийг сайжруулах

3.1.7.Албан хаагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална

4.1.1.хууль тогтоомжийн хүрээнд ажиллах

4.1.2.албан хаагч нэг бүрийг хамруулах

4.1.3.ил тод, нээлттэй хэрэгжүүлэх

4.1.4.бодитой, үр дүнтэй байх

4.1.5.нөөц бололцоог бүрэн дайчлах

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1.Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд

5.1.1.УИХ, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөнө,

5.1.2.Цалингийн нэмэгдэл, суутгал, шимтгэл зэргийг албан тушаалтан хүсвэл нэг бүрчлэн тусгасан мэдээллийг сар бүр тухайн албан тушаалтанд өгч байна.

5.1.3.Ажилтнуудад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна бусад хэлбэрээр урамшуулах боломжийг судлан хууль тогтоомжид нийцүүлэн төрийн дээд одон, медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах болон гадаад, дотоодод сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх зэргээр урамшуулна.

5.1.4.Албан хаагчдын ээлжийн амралт, нөхөн төлбөр, тэтгэвэр тэтгэмж буцалтгүй тусламж олгох зэрэг асуудлыг Хөдөлмөрийн хууль, холбогдох бусад шийдвэр, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2.Албан хаагчдыг орон сууцаар хангах, амьдрах нөхцөлийг сайжруулах боломжийг судлах зорилтын хүрээнд:

5.2.1.Албан хаагчдын орон сууцны судалгааг төрөлжүүлэн гаргаж, түүнд үндэслэн тодорхой төсөл, хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлнэ.

5.2.2.Албан хаагчдыг зуслангийн газар эзэмших эрх олж авахад туслалцаа үзүүлэх, зуслангийн байр барихад нь байгууллагын зүгээс санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх боломжийг эрэлхийлнэ.

5.2.3.Албан хаагчийг амьдрах орчин нөхцөлөө сайжруулах, орон сууц хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулах талаар судалж хууль тогтоомжийн дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

5.3.Ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд:

5.3.1.Албан хаагчдын ажиплах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлнэ.

5.3.2.Дэвшилтэд шинэ тоног төхөөрөмж, технологийг ажил албандаа нэвтрүүлэх цаасгүй технологи бий болгох, шинэ арга барилыг байнга эрэлхийлж хэрэгжүүлнэ.

5.3.3.Албан хаагчдын үдийн амралтын үеэр богино хугацаанд алжаал тайлах /цай, кофе уух, хөгжим сонсох, сонин сэтгүүл унших гэх мэт/ амрах өрөө тасалгаатай болгоно,

5.3.4.Албан үүргээ гүйцэтгэж байх үед нь хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох гүтгэх болон хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүдийг хамгаалах талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх

5.3.5.Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.3.6.Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг ажилтнуудаас санал авч судалгаа хийсний үндсэн дээр жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.

5.4.Албан хаагчдын сурч, хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

5.4.1.Мэргэжлийн болон өндөр ур чадвартай, өөрийгөө болон бусдыг байнга хөгжүүлдэг албан хаагч, хамт олныг бүрдүүлэхэд анхаарна.

5.4.2.Албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг баталж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг байгууллагын жил бүрийн төсөвт тусгаж шийдвэрлэнэ.

5.4.3.Албан хаагчдад зориулан тодорхой сэдвийн хүрээнд, үе шаттай сургалтыг зохион байгуулах талаар холбогдох газруудтай хамтран ажиллана.

5.4.4.Ажилтнуудад гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, боловсрол олгоход анхаарах

5.4.5.Бие даан болон хувиараа мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах болон хэлний сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдыг дэмжиж, мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангана.

5.4.6.Албан хаагчийг 60 хүртэлх хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгөөр дотооддоо давтан сургах мэргэшлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг нь олгоно.

5.5.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх зорилтын хүрээнд:

5.5.1.Эмнэлгийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж, албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулна.

5.5.2.Нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудыг тухай бүрд нь эмчилгээ, сувилгаа болон витаминжуулалтад хамруулах зэргээр эрүүл мэндээ хамгаалахад нь дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

5.5.3.Албан хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах спорт зааланд тогтмол тоглуулах зэрэг төрөл бүрийн спортын арга хэмжээнд хамруулж, байгууллагын спорт, биеийн тамирын арга хэмжээ тогтмолжуулна.

5.5.4.Явган болон тойрон аяллыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

5.5.5.Эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн гарын авлага, ном товхимлоор ажиллагсдыг хангах, сурталчилгааны хуудсыг мэдээллийн самбарт байршуулж ажиллана.

5.6.Албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дээрх сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд

5.6.1.Удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалтны хоорондын харилцаа хандлагын хэв маягийг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийн аятай нөхцөлийг бүрдүүлнэ.

5.6.2.Удирдах албан тушаалтны манлайллын чадавхыг хөгжүүлнэ.

5.6.3.Байгууллага хамт олны дунд найрсаг, бие биеэ хүндэтгэсэн соёлыг төлөвшүүлэх, албан хаагчдын зөв харилцаа, хандлага, сайн туршлагыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.6.4.Байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангана.

5.6.5.Албан хаагч эрхэлсэн ажил, мэргэжлийнхээ дагуу оюуны бүтээл туурвихаар бол байгууллагын зүгээс эх бэлтгэх, хэвлэх, олшруулах, олон нийтэд сурталчлах зэрэгт нь дэмжлэг үзүүлнэ.

5.6.6.Баяр ёслол, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх аялал зугаалга зохион байгуулах, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах зэргээ хамт олны уур амьсгалыг зөв төлөвшүүлэх, албан хаагчдыг үр бүтээлтэй амрах алжаалаа тайлах нөхцөл бололцоогоор хангана.

5.6.7.Байгууллага, хамт олноороо ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх болон бусад нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажлыг зохион байгуулж, албан хаагчдын нийгмийн хүрээн дэх байр суурийг өргөжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

6.1.Хөтөлбөрийг 2026-2030 онд хэрэгжүүлнэ.

6.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ

- нийслэлийн төсвийн санхүүжилт,
- олон улсын байгууллагын дэмжлэг, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт - Гадаад упс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн зардлаар,
-бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдах ба зохион байгуулалт, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан менежер хариуцна.

7.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиплагааны төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжилтийг зохион байгуулна.

7.3.Албан хаагчдад олгох зарим хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийн хэмжээ, чөлөө зөвшөөрлийн хугацаа зэрэг хууль тогтоомжид заагдаагүй асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусгаж хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан менежер хяналт тавих ба хөтөлбөрийн хэрэгжилтэд 2 жил тутам хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг жил бүрийн эцэст албан хаагчдад мэдээлнэ.

8.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар удирдлага, албан хаагчид тодорхой санал, хүсэлт гаргаж болох ба хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, албан хаагчдын санал хүсэлтийг үндэслэн хөтөлбөрт тодотгол хийж нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хамаарах хууль, тогтоомж, дүрэм, журам өөрчлөгдсөн тохиолдол бүрт нэмэлт тайлбар тодруулга хийнэ.

Ес.Хөтөлбөрийн үр дүн

9.1.Албан хаагчид хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, ажлын үзүүлэлт, хөдөлмөрийн бүтээмжид нь ахиц, өөрчлөлт гарна.

9.2.Хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар бүрэн хангагдана.

9.3.Албан хаагчийн амьдрал ахуй, орон байрны асуудал сайжирна

9.4.Албан хаагчийн цалин хангамж нэмэгдэнэ

9.5.Албан хаагчид тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл сайжирна. 9.6.Энэхүү хөтөлбөр болон уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө нь дараагийн хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, суурь судалгаа болно.

-oooOOOooo-